



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Утас: 99911390

цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b>	<b>3-4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>4</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	<b>11</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	<b>13</b>
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	<b>13</b>
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	<b>13</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	<b>14</b>
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	<b>14</b>
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	<b>14</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>14</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	<b>14</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>15</b>
<b>4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	<b>15</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>15</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>17</b>

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОУБ	Олон улсын байгууллага



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.БАЯРТУЯА ТАНАА

2023.02.24 № 02/76  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд ГБХЗХГазраас 10,105.0 сая, ЗДНХ-өөс 17,689.2 сая төгрөгийн санхүүжилтээр Хүүхдийн баян булаг зуслангийн засвар үйлчилгээнд зарцуулж олон жил үйл ажиллагаа явуулаагүй хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг эхлүүлж 100 хүүхэд хүлээн авч амраасан байна. НҮБ-аас “Хамтдаа даван туулья” төслөөр 30,958.0 мянган төгрөг, Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс Түр хамгаалах байрны “Эерэг өөрчлөлт” төслөөр шалгарч 15,750.7 мянган төгрөг нийт 46708.7 сая төгрөгийн санхүүжилт авч орон нутагт Хүүхэд хамгаалах, Гэр бүлд чиглэсэн, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

2022 онд 4 зорилт 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлт 89 хувьтай байна. Хүүхдийн 108 утсаар шилжүүлсэн дуудлага мэдээллийг бүрэн шийдвэрлэж 73 өрхөд үйлчилгээ үзүүлж, хамгаалах байранд нийт 49 кейс үйлчлүүлсэн байна.

021020385

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>66,433,040.32</u></b>	<b><u>61,961,377.32</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	310,029.32	226,919.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	226,919.32	226,919.32
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	83,110.00	-
3351	Байгууллагаас авах авлага	83,110.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	66,123,011.00	61,734,458.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	66,123,011.00	61,734,458.00
35420	Аж ахуйн материал	64,355,111.00	61,734,458.00
35440	Түлш, шатах тослох материал	1,767,900.00	-
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,420,475,022.24</u></b>	<b><u>1,381,214,612.70</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,420,475,022.24	1,381,214,612.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,338,470,584.68	1,299,305,175.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,147,150,280.00	1,147,150,280.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,357,514.08)	(76,476,685.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,658,333.26)	(9,008,333.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,180,167.00	191,191,367.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(110,909,565.23)	(131,392,222.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	180,954,856.00	187,178,796.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(150,132,689.31)	(157,331,409.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,367,170.00	178,367,170.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(62,389,786.44)	(68,639,786.40)
39217	Ном	14,766,000.00	14,766,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	82,004,437.56	81,909,437.52
39301	Програм хангамж	7,093,000.00	7,093,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,993,162.44)	(6,088,162.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,904,600.00	80,904,600.00
<b>394</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,486,908,062.56</u></b>	<b><u>1,443,175,990.02</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>18,801.66</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	18,801.66	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	18,801.66	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	18,801.66	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,486,889,260.90</u></b>	<b><u>1,443,175,990.02</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,486,889,260.90	1,443,175,990.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,301,682,672.00	1,301,682,672.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(613,063,997.19)	(656,777,268.07)
51210	Өмнөх үеийн үр дүн	(646,833,389.33)	(613,063,997.19)
51220	Тайлант үеийн үр дүн	33,769,392.14	(43,713,270.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,270,586.09	798,270,586.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,486,908,062.56</u></b>	<b><u>1,443,175,990.02</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>819,834,100.00</b>	<b>853,721,231.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>45,414,200.00</b>	<b>2,033,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	45,414,200.00	2,033,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,414,200.00	2,033,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,093,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,321,200.00	2,033,400.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>774,419,900.00</b>	<b>851,687,831.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,210,500.00	689,075,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	689,075,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	545,210,500.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,599,900.00	162,612,331.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	46,708,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,466,900.00	50,063,916.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,133,000.00	48,881,715.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,958,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	143,609,500.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,609,500.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>786,064,707.86</b>	<b>897,434,501.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>786,064,707.86</b>	<b>897,434,501.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	707,491,224.60	880,185,901.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,430,445.00	344,746,200.00
210101	Үндсэн цалин	263,553,975.00	264,733,687.82
210102	Нэмэгдэл	-	52,100,008.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	15,430,500.00
210104	урамшуулал	36,876,470.00	12,482,004.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,313,573.24	43,093,200.00
210201	Тэтгэврийн даатгал	27,352,012.06	30,682,714.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,993,894.77	3,438,232.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,395,115.81	2,750,585.87
210204	Ажилгүйдлийн даатгал	584,761.06	658,824.39
210205	Эрүүл мэндийн даатгал	5,987,789.54	6,588,243.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	141,182,391.00	122,907,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,749,262.00	2,608,800.00
210302	Түлш, халаалт	134,000,748.00	115,145,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,432,381.00	5,153,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	126,264,293.50	3,677,900.00
210401	Бичиг хэрэг	635,500.00	1,003,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,047,800.50	1,228,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,279,700.00	682,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	164,000.00	764,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	119,137,293.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	17,752,851.00
210604	Урсгал засвар	-	17,752,851.00

2107	Томилолт, зочны зардал	-	262,100.00
210702	Дотоод албан томилолт	-	262,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,332,681.76	152,625,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,371,001.76	151,083,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	361,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	166,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,680.00	55,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,000.00	30,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	342,000.00	420,200.00
210807	Газрын төлбөр	-	508,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,967,840.10	195,120,990.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,654,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,765,417.00	139,625,441.34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,548,423.10	55,495,549.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,573,483.26	17,248,600.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,192,600.00	17,248,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,192,600.00	17,248,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,380,883.26	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,380,883.26	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>33,769,392.14</b>	<b>(43,713,270.88)</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>33,769,392.14</b>	<b>(43,713,270.88)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>777,833,600.00</b>	<b>851,687,831.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,093,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,093,000.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,093,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,093,000.00	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>774,740,600.00</b>	<b>851,687,831.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	545,210,500.00	689,075,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	545,210,500.00	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	85,920,600.00	162,612,331.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,787,600.00	50,063,916.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шагны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,133,000.00	48,881,715.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	143,609,500.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,609,500.00	-

2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>777,833,600.00</b>	<b>851,687,831.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>777,833,600.00</b>	<b>851,687,831.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>699,260,116.74</b>	<b>834,439,231.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	236,950,064.00	344,746,200.00
210101	Үндсэн цалин	139,087,500.00	264,733,687.82
210102	Нэмэгдэл	54,860,800.00	52,100,008.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,157,029.00	15,430,500.00
210104	Урамшуулал	29,530,935.00	12,482,004.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,313,800.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,362,100.00	43,093,200.00
210201	Тэтгэврийн даатгал	22,773,300.00	29,750,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,397,300.00	3,335,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,917,700.00	2,668,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	479,400.00	667,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,794,400.00	6,671,400.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	142,643,048.00	122,907,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,634,500.00	2,608,800.00
210302	Түлш, халаалт	134,000,748.00	115,145,400.00
210303	Цэвэр, бохир ус	4,007,800.00	5,153,200.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,232,850.00	3,677,900.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	1,003,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,763,550.00	1,228,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	849,300.00	682,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,120,000.00	764,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	17,752,851.00
210604	Урсгал засвар	-	17,752,851.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	-	262,100.00
210702	Дотоод албан томилолт	-	262,100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	194,711,279.74	149,305,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,591,599.74	147,383,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	361,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	166,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,680.00	55,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,000.00	30,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	420,200.00
210807	Газрын төлбөр	-	888,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	86,360,775.00	152,693,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,104,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,256,075.00	152,693,680.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,573,483.26</b>	<b>17,248,600.00</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	68,192,600.00	17,248,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,192,600.00	17,248,600.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,380,883.26	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,380,883.26	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>≡</b>	<b>≡</b>

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> <b>(8)=(3)+(6)+(7)</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(646,833,389.33)	1,453,119,868.76
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(646,833,389.33)	1,453,119,868.76
C07	Тайлант үеийн үр дүн			33,769,392.14	33,769,392.14
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(613,063,997.19)	1,486,889,260.90
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(613,063,997.19)	1,486,889,260.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(613,063,997.19)	1,486,889,260.90
D08	Тайлант үеийн үр дүн			(43,713,270.88)	(43,713,270.88)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672.00	798,270,586.09	(656,777,268.07)	1,443,175,990.02

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	689,075,500.00	689,075,500.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	689,075,500.00	689,075,500.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	671,826,900.00	671,826,900.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	344,746,200.00	344,746,200.00
210101	Үндсэн цалин	302,096,600.00	253,998,729.94
210102	Нэмэгдэл	37,567,600.00	46,811,983.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,082,000.00	32,101,169.40
210104	Урамшуулал	-	11,834,317.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,093,200.00	43,093,200.00
210201	Тэтгэврийн даатгал	29,750,400.00	29,750,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,335,700.00	3,335,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,668,600.00	2,668,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	667,100.00	667,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,671,400.00	6,671,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,907,400.00	122,907,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,608,800.00	2,608,800.00
210302	Түлш, халаалт	115,145,400.00	115,145,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,153,200.00	5,153,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,677,900.00	3,677,900.00

210401	Бичиг хэрэг	1,003,300.00	1,003,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,228,200.00	1,228,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	682,300.00	682,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	764,100.00	764,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	63,600.00	63,600.00
210604	Урсгал засвар	63,600.00	63,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	262,100.00	262,100.00
210702	Дотоод албан томилолт	262,100.00	262,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	149,305,900.00	149,305,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,763,700.00	147,383,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	361,400.00	361,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	166,400.00	166,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,400.00	55,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,300.00	30,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,200.00	420,200.00
210807	Газрын төлбөр	508,500.00	888,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,770,600.00	7,770,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,770,600.00	7,770,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,248,600.00	17,248,600.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,248,600.00	17,248,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,248,600.00	17,248,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	689,075,500.00	689,075,500.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	689,075,500.00	689,075,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	689,075,500.00	689,075,500.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>162,612,331.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>162,612,331.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	162,612,331.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,689,251.00
210604	Урсгал засвар	17,689,251.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	144,923,080.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	144,923,080.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	162,612,331.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	162,612,331.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	46,708,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,063,916.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,881,715.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,958,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө “Гэр бүлийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг мэргэжил арга зүйгээр хангах, чадавхжуулах”, “Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх”, “Өсвөр үе, залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж, нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлж, салбар дундын уялдааг хангах”, “Төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны болон хүний нөөцийн нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, тэгш хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Эрүүл бие бялдартай хүүхдийг төлөвшүүлж эрүүл зөв дадлыг хэвшүүлнэ”, “Зөв эерэг хандлагатай хүүхдийг төлөвшүүлнэ”, “Мэдлэгээ хэрэглээ болгоход анхаарч бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ” гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/63 дугаар тушаалын 1 хавсралтаар удирдлага-1, гүйцэтгэх албан тушаалтан-14, залуучуудын хөгжлийн төв-1, түр хамгаалах байр-12, хүүхдийн зуслан-1, байр ашиглалт-6 нийт 35 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны А/39 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.8 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсантай холбоотой

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0.3	0.2	(0.1)
Бараа материал	66.1	61.7	(4.4)
Үндсэн хөрөнгө	1,420.5	1,381.2	(39.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,486.9</b>	<b>1,443.1</b>	<b>(43.8)</b>
Өр төлбөр	0.02	-	(0.02)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,301.7	1,301.7	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,486.9</b>	<b>1,443.1</b>	<b>(43.8)</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Бараа материал 4.4 сая төгрөгөөр буурсан бараа материал, хандиваар 4.8 сая төгрөгийн бараа материалууд хүлээн авсан холбоотой байна.
- ✓ 2022 онд төслийн хөрөнгөөр Хүлэмж, гал тогооны тоног төхөөрөмж, оёдлын сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж, компьютер өнгөт принтер гэх мэт нийт 14.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 689.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 689.0 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж 100 биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72207/80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	524.0	524.0	-	100%
2	72207/80236-сургалт семинар	7.26	7.26	-	100%
3	72207/80237 –Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	58.0	58.0	-	100%
4	72207/80238-Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	56.0	56.0	-	100%
5	72207/80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	17.3	17.3	-	100%
6	72209/83115/-залуучууд болон оюутнууд	18.5	18.5	-	100%
7	72212/83115-гэр бүлийн хөгжил хамгаалал	8.0	8.0	-	100%
	Нийт	689.0	689.0		100%

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны байгууллагаас 48.9 сая төгрөг, ЗДНХ-өөс 50.0 сая төгрөг НҮБ-аас “Хамтдаа даван туулья” төслөөр 31.0 сая төгрөг, Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслөөс Түр хамгаалах байрны “Эерэг өөрчлөлт” төслөөр шалгарч 15.7 сая, өөрийн үйл ажиллагааны орлогоос 17.0 сая нийт 162.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж үндсэн хөрөнгө худалдан авахад 14.6 сая, хилийн цэргийн ангийн дэргэдэх хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтэд 36.5 сая төгрөг Баян булаг зуслангийн урсгал засварт 17.7 сая төгрөг, хүүхэд хамгаалах, залуучуудын оролцоог дэмжих, урьдчилан сэргийлэх сургалт семинарын зардалд зарцуулж хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 18-ний өдрөөс 02 дүгээр сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 786.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр тогтоосон байсныг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 13.5 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 10.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлээгүй байна.*

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээг бүрэн мэдээллэж, төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээллээгүйг аудитын явцад залруулан мэдээллүүлээ.

#### 4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнгийн тайлан, төсвийн дагуу гүйцэтгэлийн товч тайлан авч төсвийн хөрөнгийн үр өгөөжийг хянаж хэвшээгүйтэй холбоотой 7.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
<b>Зөвлөмж</b>	<b>2</b>	<b>7.2</b>	<b>2</b>	<b>7.2</b>	<b>100.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>7.2</b>	<b>2</b>	<b>7.2</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1 алдааг залрууллаа. Үүнд: төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд оруулаагүй системд байршуулж залрууллаа.

Аудитаар нийт 8.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.2 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

- ✓ Дэлхийн зөн ОУБ-аас 1.0 сая төгрөг НҮБ-аас-0.8 сая төгрөгөөр хурлын заалыг түрээсэлсэн түрээсийн төлбөрийн 40 хувийг улсын төсөвт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төвлөрүүлээгүй, Байгууллагын төсвөөс ХХОАТ-т 0.3 сая төгрөгийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" ТӨБЗГ-ын 49 дүгээр тогтоолын 49.2 "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **5.3 Зөвлөмж**

#### **5.3.1 Цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой**

**Илрүүлэлт:** Албан хаагчдад илүү цагаар ажилсан нэмэгдэл хөлс олгохдоо нормативаас хэтрүүлж олгосон, илүү цагийн хөлс тооцох маягтын дагуу тооцоогүй зөрчил нь Засгийн газрын 382 тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 1 " Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу *Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна,* " Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж :** *Засгийн газрын тогтоол баримтлан илүү цагийн нэмэгдэл хөлс олгож хэвших,*

#### **5.3.2 Цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой**

**Илрүүлэлт:** Түр хамгаалах байрны гэрээт эмчийн цалин хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй зөрчил нь *Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" 32 дугаар зүйлд "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор" 18.1-д "Нягтлан бодох*

бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээт эмчийн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлж хэвших

### 5.3.3 Зардлын данстай холбоотой

**Илрүүлэлт:** Кейстэй холбоотой хичээлийн хоцрогдол арилгах сургалтад хамруулахаар 12 сард нэг жилийн хугацаатай гэрээ байгуулж төлбөрийг бүрэн шилжүүлж зардалд бүртгэсэн гүйцэтгэлийн тайлан ирээгүй зөрчил, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ. 16 дугаар зүйлийн 16.5.1-д “ Төсөвт байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах ” 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйлгээ гарсан үед нь данс бүртгэлд тусгаж хэвших

Дээрх төлбөрийн акт зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансанд Төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээллээгүй	1.0	-	1.0	-	-	-	1.0	-	-	-	-	-
Дүн	1.0	-	1.0	-	-	-	1.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Кейстэй холбоотой хичээлийн хоцрогдол арилгах сургалтад хамруулахаар 12 сард нэг жилийн хугацаатэй гэрээ байгуулж төлбөрийг бүрэн шилжүүлж зардалд бүртгэсэн	1	2,200.0					1	2,200.0
Татварын хэлтэст илүү ХХОАТ илүү шилжүүлсэн, түрээсийн орлогын 40 хувь төвлөрүүлээгүй	1	1,060.0	1	1,060.0				
Илүү цагийн нэмэгдэл хөлсийг маягтын дагуу олгоогүй	1	-					1	-
Түр хамгаалах байрны гэрээт эмчийн цалингаас НДШ суутгаагүй олгосон	1	5,040.0					1	5,040.0
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>8,300.0</b>	<b>1</b>	<b>1,060.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>7,240.00</b>


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:



С.ОЮУНЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

31/2170430

Дугаар

ХОА-2022/39/НА-СТА-ТШЗ

2023 оны 06 сарын 24 өдөр

Ховд

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Дэлхийн зөн ОУБ-аас 1080.0 мянган төгрөг, НҮБ-аас 750.0 мянган төгрөгөөр тус тус хурлын заалыг түрээсэлж түрээсийн төлбөрийн 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, байгууллагын төсвөөс ХХОАТ руу 0.3 сая төгрөгийг илүү шилжүүлсэнтэй холбоотой нийт 1060.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7 дугаар зүйлийн 7.7-д "энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" ТӨБЗГ-ын 49 дүгээр тогтоолын 49.2 "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1060.0 мянган төгрөг / нэг сая жаран мянган/-ийг бусад нэр зааж ангилагдаагүй орлогын төрийн сан банкны 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.Баяртуяа, нягтлан бодогч Ш.Отгонцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

АУДИТОР  С.ОЮУНЖАРГАЛ

